

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 04-ний өдөр

№ 19/51

Улаанбаатар хот

Чанаргүй болон муу активыг Зээлийн эрсдэлийн сангаас хорогдуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны 144/125 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 3.6.4 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.22 дахь заалт, ЛэндМН ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит бус хурлаар гишүүдээс ирүүлсэн эчнээ санал хураалтын дүнг үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

1. Компанийн Гүйцэтгэх удирдлагын саналыг үндэслэн 208,928,800 (хоёр зуун найман сая есөн зуун хорин найман мянга найман зуу) төгрөгтэй тэнцэх чанаргүй болон муу зээл, тэдгээрт тооцогдсон 12,259,599 (арван хоёр сая хоёр зуун тавин есөн мянга таван зуун ерэн ес) төгрөгийн төлөгдөөгүй шимтгэлийн авлагын төлбөрийг Зээлийн эрсдэлийн сангаас хорогдуулах, түүнтэй холбоотой холбогдох нягтлан бодох бүртгэлийн гүйлгээг 2019 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр хийх эрхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т олгосугай.
2. Зээлийн эрсдэлийн сангаас чанаргүй болон муу активыг хорогдуулах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн актууд болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын шаардлагуудад нийцүүлэн гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.

